



ИХ СУРГУУЛИУДЫН ХОТХОНЫ
АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ЗАХИРГААНЫ
ЗАХИРАЛ Ю.ЭНХБАТ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23 № 3/292

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

[Signature]

Ц.НАРАНЧИМЭГ



“ИХ СУРГУУЛИУДЫН ХОТХОНЫ АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ЗАХИРГАА” УТГ

2016 оны санхүүгийн тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

САГ-ын дарга:Ц. Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг:
naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер:Я. Самбууням
Утас: 260512
Цахим хаяг:
sambuunyamya@audit.gov.mn

Аудитор: Б.Сэржмядаг
Утас: 260512
Цахим хаяг:
serjmyadagb@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын газар, 3Г-ын 4-р байр

Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

“Релаэнс секюритиз аудит”ХХК

Ахлах аудитор: Ч.Оюун
Утас: 99186670

Туслах аудитор: Г. Оюун-Эрдэнэ
Утас:99969118

Хаяг: БЗД, 26-р хороо, Энканто таун,
306-р байр, 1-р давхар, 32 тоот Улаанбаатар хот.

Аудитынтайлан

Хавсралт 1: Аудитын тайлан

Хавсралт 2: Аудитынгэрчилгээ

Хавсралт 3: Менежментийнзахидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

2017 оны 2 сарын 15

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын аргазүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Материаллаг байдал
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Зөвлөмж
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, 18 дугаар зүйлийн 18.3-д зааснаар Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа” УТГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд, АОУС болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа” УТГ-ын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

““Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа” УТГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 28-наас 2017 оны 2 дугаар сарын 18-ны хооронд хийхээр төлөвлөн “Релаэнс секюритиз аудит” ХХК-д хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа” УТГ-ын 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 2 дугаар сарын 8-нд “Релаэнс секюритиз аудит” ХХК-д ирүүлсэн байна.

“Релаэнс секюритиз аудит” ХХК аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 28-наас 2017 оны 2 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 23-нд “Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа” УТГ-ын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа” УТГ-ын төсвийн захирагч нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Компанийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол

хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэх ажлыг удирдан, зохион байгуулах зорилгоор 2010 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн Монгол Улсын Засгийн Газрын 56 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг, 2010 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн Монгол Улсын Засгийн Газрын 149 дүгээр тогтоолоор батлагдсан чиглэлийн дагуу үйл ажиллагааг явуулж байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн байгууллагын захирагч нь тус байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу “Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа” УТГ-ын захирлаар БСШУ-ны Сайдын 2010 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 303 тоот тушаалаар томилогдсон Ю. Энхбат төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. 2016 оны төсвийг Сангийн яамны Төрийн сангаас олгож байна.

Их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэн, үндэсний их сургуулиудыг чадавхижуулан сургалт, судалгаа, шинжлэх ухаан, үйлдвэрлэл бизнесийн холбоог бэхжүүлж олон улсад өрсөлдөх чадвартай дээд боловсролын тогтолцоог эх орондоо бий болгон, ажиллаж амьдрах таатай нөхцөл бүрдсэнээр баялагт суурилсан эдийн засгаас мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих үндэс суурийг тавих зорилготой.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль мөн бусад холбогдох хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа” УТГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитынарга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа” УТГ-ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 17-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа” УТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан салбарын сайдын А/02 тушаалаар батлуулан 2013 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай болон Нягтлан бодох бүртгэлийн програмтай нийцсэн байна.

“Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа” УТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа” УТГ-н санхүүгийн нүлжиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг түвшин:

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг цэвэр хөрөнгийн 1 хувиар тогтоож, хүлээн зөвшөөрөх алдааны түвшинг 15.7 сая төгрөг гэж тооцов. Нийт орлого болон зардлаас материаллаг түвшинг тогтооход материаллаг түвшин бага гарч байгаа тул цэвэр хөрөнгөөр материаллаг түвшинг тогтоох нь зохимжтой гэж үзсэн.

Дотоод хяналт:

“Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа” УТГ-ын Санхүүгийн үйл ажиллагааг Ерөнхий нягтлан бодогч болон Даргийн үүрэг гүйцэтгэгч хянадаг.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавинажилласан байна.

“Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа” УТГ-ын төсвийн захирагч нь 2016 онд улсын төсвөөс 234.4 сая төгрөгийн санхүүжилт авч ажиллахаас 226.3 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авсан. Үүнээс урсгал зардалд 226.3 сая төгрөг зарцуулсан байна. Төсвийн гүйцэтгэл 96.6 хувьтай байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн

удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан талаар тодорхой тусган ажиллаж байна.

Шилэн дансны кодыг Сангийн яамнаас 2015 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр авч, 2015 оны 2 дугаар сарын 2-ны өдрөөс эхлэн Батлагдсан төсөв, төлөвлөлт, гүйцэтгэл, төсөвт орсон өөрчлөлт, мэдээ мэдээллүүдийг сар, улирал, хагас жил, жилийн эцсийн байдлаар <http://shilendans.gov.mn/> сайтад байршуулсан.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 1 эрсдлийг тогтоож батламж мэдэгдэлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 1 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

“Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа” УТГ-ын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бусад орлого, бичиг хэрэг, шуудан холбоо, төлбөр хураамж, сургалт семинар зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 99.4 хувь, нийт зардлын 99.6хувь, нийт хөрөнгийн 95хувийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар дараах материаллаг бус зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 439 дүгээр тогтоолын дагуухийсэн Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогоор 8.1 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 0.3 сая төгрөгийн тавилга эд хогшил, нийт 8.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө чанарын шаардлага хангаагүйгээс ашиглагдахгүй байна.

Шийдвэрлэсэн: 2016 оны жилийн эцсийн тооллогын дүгнэлт саналыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэст хүргүүлж шийдвэрлүүлэх.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Залруулагдаагүй алдааны талаар ямар нэгэн тайлбар байхгүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

“Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа” УТГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа” УТГ-н төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 8.4 сая төгрөгийн алдаа илэрсэн ба үүнээс 8.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн 2015 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 3 зөвлөмж өгсөн бөгөөд 2 зөвлөмж нь хэрэгжсэн байна.



“ИХ СУРГУУЛИУДЫН ХОТХОНЫ АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ЗАХИРГАА”

2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Үндсэн хөрөнгө.....2

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа” УТГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын султал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа” УТГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Үндсэн хөрөнгө	Тэргүүлэхачхолбогдол №1
----------------------------------	--------------------------------

ҮАГ-ынажиглалт

1.Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 439 дүгээр тогтоолын дагуу хийсэн Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогоор 8.1 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 0.3 сая төгрөгийн тавилга эд хогшил, нийт 8.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө чанарын шаардлага хангаагүйгээс ашиглагдахгүй байна.

Эрсдэлүүд

Ашиглалтаас гарсан үндсэн хөрөнгийг данснаас хасалт хийгээгүйн улмаас үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нэмэгдэж, зардал өснө.

ҮАГ-ынзөвлөмж

2016 оны жилийн эцсийн тооллогын дүгнэлт саналыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэст хүргүүлж шийдвэрлүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

2017 онд шийдвэрлэнэ.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

д/д	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	-
2	Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөг/	-	-
3	АВЛАГА	1,867,585.00	759,090.00
4	Бусад авлага	1,867,585.00	759,090.00
5	БАРАА МАТЕРИАЛ	25,184,427.01	26,112,245.01
6	Хангамжийн материал	25,184,427.01	26,112,245.01
7	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	27,052,012.01	26,871,335.01
8	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
9	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		
10	Биет хөрөнгө	107,587,083.66	76,994,840.25
11	Машин, тоног төхөөрөмж	46,635,158.00	46,849,658.00
12	Хуримтлагдсан элэгдэл	(30,461,327.53)	(38,675,474.38)
13	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,259,300.00	9,259,300.00
14	Хуримтлагдсан элэгдэл	(3,344,097.81)	(4,270,027.65)
15	Авто тээврийн хэрэгсэл	130,000,000.00	130,000,000.00
16	Хуримтлагдсан элэгдэл	(45,138,889.00)	(66,805,555.72)
17	Номын фонд	636,940.00	636,940.00
18	Биет бус хөрөнгө	1,567,970,987.86	1,473,240,285.10
19	Програм хангамж	1,193,100.00	1,193,100.00
20	Хасагдуулга	(1,193,100.00)	(1,193,100.00)
21	Бусад	1,641,675,903.20	1,641,675,903.20
22	Хасагдуулга	(73,704,915.34)	(168,435,618.10)
23	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,675,558,071.52	1,550,235,125.35
24	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,702,610,083.53	1,577,106,460.36
25	Богино хугацаат өр төлбөр		
26	Өглөг	-	-
27	Ажиллагчидтай холбогдсон өглөг	-	-
28	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
29	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		
30	Засгийн газрын оруулсан капитал	320,863,673.00	320,863,673.00
31	Өмнөх үеийн үр дүн	1,381,746,410.53	1,381,746,410.53
32	Тайлант үеийн үр дүн		(125,503,623.17)
33	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,702,610,083.53	1,577,106,460.36
34	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,702,610,083.53	1,577,106,460.36

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

д/д	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
2	Улсын төсөвөөс	258,006,680.00	234,424,400.00
3	Урсгал	258,006,680.00	234,424,400.00
4	Төсөвт байгууллагын ажил үйлчилгээний орлого	297,859,894.00	-
5	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	300,000.00	-
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	297,559,894.00	-
7	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	555,866,574.00	234,424,400.00
8	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
9	АЖИЛЛАГЧИДАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ		
10	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	114,545,490.00	109,746,558.00
11	Цалин	114,545,490.00	109,746,558.00
12	Нийгмийн хамгааллын шимтгэл	12,600,003.90	12,117,049.38
13	Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	10,309,094.10	9,922,118.22
14	Тэтгэврийн даатгалын шимтгэл	8,018,184.30	7,722,579.06
15	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	916,363.92	882,580.46
16	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,145,454.90	1,097,465.58
17	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	229,090.98	219,493.12
18	Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,290,909.80	2,194,931.16
19	Тогтмол зардал	12,040,000.00	26,745,000.00
20	Байрны түрээс	12,040,000.00	26,745,000.00
21	Хангамж бараа материалын зардал	4,785,377.68	8,450,732.00
22	Бичиг хэргийн материал	928,730.00	989,430.00
23	Тээвэр, шатахууны зардал	2,783,117.68	6,209,682.00
24	Шуудан холбооны зардал	538,330.00	837,120.00
25	Ном, хэвлэлийн зардал	535,200.00	
26	Бага үнэ түргэн элэгдэх зүйлс		414,500.00
27	Эд хогшил, урсгал засварын зардал	2,840,800.00	2,496,600.00
28	Урсгал засварын зардал	2,840,800.00	2,496,600.00
29	Томилолт, зочны зардал	14,581,639.00	19,850,195.00
30	Гадаад томилолтын зардал		17,690,100.00
31	Дотоод томилолтын зардал	8,330,640.00	1,372,595.00
32	Гадаад зочны зардал	6,250,999.00	787,500.00
33	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	59,188,784.00	46,897,567.00
34	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	56,947,784.00	43,999,667.00
35	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох	500,000.00	1,000,000.00
36	Тээврийн хэрэгслийн татвар	193,500.00	193,500.00
37	Тээврийн хэрэгслийн оношилгоо	200,000.00	200,000.00
38	Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс	1,347,500.00	1,494,000.00
39	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээ		10,400.00
40	Бараа үйлчилгээний бусад зардал	106,658,052.16	125,537,446.17
41	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	106,658,052.16	125,537,446.17
42	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	318,525.10	8,086,875.62
43	Засгийн газрын урсгал шилжүүлэг	318,525.10	8,086,875.62
44	Төвлөрүүлэх шилжүүлэг	318,525.10	8,086,875.62
45	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	327,558,671.84	359,928,023.17
46	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	228,307,902.16	(125,503,623.17)
47	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		
48	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	165,433.22	
49	Үндсэн хөрөнгө худалдаалсны гарз	165,433.22	

50	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	228,142,468.94	(125,503,623.17)
----	-----------------------------	----------------	------------------

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

д/д	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	258,006,680.00	238,177,868.00
2	Улсын төсөвөөс	258,006,680.00	234,424,400.00
3	Урсгал	258,006,680.00	234,424,400.00
4	Нийгмийн даатгалын сангаас		3,753,468.00
5	Бараа, үйлчилгээний орлого	300,000.00	5,700,328.21
6	Төсөвт байгууллагын ажил үйлчилгээний орлого	300,000.00	5,700,328.21
7	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	258,306,680.00	243,878,196.21
8	Ажиллагчидтай холбогдсон зардал	114,545,490.00	113,500,026.00
9	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	114,545,490.00	113,500,026.00
10	Нийгмийн хамгааллын шимтгэл	12,600,003.90	12,117,049.38
11	Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	10,309,094.10	9,922,118.22
12	Тэтгэврийн даатгалын шимтгэл	8,018,184.30	7,722,579.06
13	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	916,363.92	882,580.46
14	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,145,454.90	1,097,465.58
15	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	229,090.98	219,493.12
16	Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,290,909.80	2,194,931.16
17	Бараа үйлчилгээний урсгал зардал	114,491,661.00	109,959,745.21
18	Хангамж бараа материалын зардал	4,772,260.00	10,166,050.00
19	Бичиг хэргийн материал	928,730.00	989,430.00
20	Тээвэр, шатахууны зардал	2,770,000.00	7,665,000.00
21	Шуудан холбооны зардал	538,330.00	837,120.00
22	Ном, хэвлэлийн зардал	535,200.00	
23	Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд		674,500.00
24	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,040,000.00	26,745,000.00
25	Байрны түрээс	12,040,000.00	26,745,000.00
26	Эд хогшил урсгал засварын зардал	2,840,800.00	2,496,600.00
27	Урсгал засвар	2,840,800.00	2,496,600.00
28	Томилолт, зочны зардал	12,875,840.00	17,954,200.00
29	Гадаад томилолтын зардал		17,690,100.00
30	Дотоод томилолтын зардал	8,017,240.00	264,100.00
31	Гадаад зочны зардал	4,858,600.00	
32	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	81,962,761.00	46,897,567.00
33	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	79,721,761.00	43,999,667.00
34	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох	500,000.00	1,000,000.00
35	Тээврийн хэрэгслийн татвар	193,500.00	193,500.00
36	Тээврийн хэрэгслийн оношилгоо	200,000.00	200,000.00
37	Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс	1,347,500.00	1,494,000.00
38	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээ		10,400.00
39	Бараа үйлчилгээний бусад зардал		5,700,328.21
40	Бараа үйлчилгээний бусад зардал		5,700,328.21
41	ТАТААС	318,525.10	8,086,875.62
42	Төвлөрүүлэн шилжүүлэг	318,525.10	8,086,875.62
43	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (I)	241,955,680.00	243,663,696.21
44	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	16,351,000.00	214,500.00

45	Хөрөнгийн орлого		
46	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,356,000.00	214,500.00
47	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	16,356,000.00	214,500.00
48	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(16,356,000.00)	(214,500.00)
49	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
50	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(5,000.00)	0.00
51	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,000.00	-
52	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Аудитлагдсан өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1		-	-	-	-
2	2015 оны 1 сарын 1 ний үлдэгдэл	320,863,673.00	-	1,137,768,441.59	1,458,632,114.59
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	15,835,500.00	15,835,500.00
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	320,863,673.00	-	1,153,603,941.59	1,474,467,614.59
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
6	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
7	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
8	Тайлант үеийн үр дүн	-	-	228,142,468.94	228,142,468.94
9		-	-	-	-
10	2015 оны 12 сарын 31 ний үлдэгдэл	320,863,673.00	-	1,381,746,410.53	1,702,610,083.53
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	320,863,673.00	-	1,381,746,410.53	1,702,610,083.53
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
16	Тайлант үеийн үр дүн	-	-	(125,503,623.17)	(125,503,623.17)
17	2016 оны 12 сарын 31 ний үлдэгдэл	320,863,673.00	-	1,256,242,787.36	1,577,106,460.36

АУДИТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	ҮЗҮҮЛЭЛТ	төлөвлөгөө	ГҮЙЦЭТГЭЛ
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	234,424,400.00	226,337,524.38
2	II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	234,424,400.00	226,337,524.38
3	IV УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	234,424,400.00	226,337,524.38
5	Бараа, үйлчилгээний зардал	234,424,400.00	226,337,524.38
6	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	114,551,800.00	109,746,558.00
	Үндсэн цалин	114,551,800.00	109,746,558.00
	Ажилгүйдлийн даатгал	229,100.00	219,493.12
7	Нийгмийн хамгааллын шимтгэл	12,600,600.00	12,117,049.38
8	Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	10,309,600.00	9,922,118.22
9	Тэтгэврийн даатгалын шимтгэл	8,018,600.00	7,722,579.06
10	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	916,400.00	882,580.46
11	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,145,500.00	1,097,465.58
13	Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,291,000.00	2,194,931.16
14	Бараа үйлчилгээний урсгал зардал	107,272,000.00	104,473,917.00
15	Хангамж бараа материалын зардал	10,382,900.00	10,380,550.00
16	Бичиг хэргийн материал	582,100.00	989,430.00
17	Тээвэр, шатахууны зардал	7,754,000.00	7,665,000.00
18	Шуудан холбооны зардал	501,400.00	837,120.00
20	Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд	1,545,400.00	889,000.00
21	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,600,000.00	26,745,000.00
22	Байрны түрээс	27,600,000.00	26,745,000.00
23	Эд хогшил урсгал засварын зардал	3,156,900.00	2,496,600.00
24	Урсгал засвар	3,156,900.00	2,496,600.00
25	Томилолт, зочны зардал	17,954,200.00	17,954,200.00
26	Гадаад томилолтын зардал		17,690,100.00
27	Дотоод томилолтын зардал	17,954,200.00	264,100.00
29	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	48,178,000.00	46,897,567.00
30	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	45,000,000.00	43,999,667.00
31	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00
32	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	193,500.00
33	Тээврийн хэрэгслийн оношилгоо	200,000.00	200,000.00
34	Мэдээлэл технологийнүйлчилгээний хөлс	1,500,000.00	1,494,000.00
35	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээ	78,000.00	10,400.00
36	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	234,424,400.00	226,337,524.38
37	Төсвөөс санхүүжих	234,424,400.00	226,337,524.38